蒙古国实施了国家微生物监控计划，并定期向中方提供其年度微生物监控计划和上一年度监控报告。

必要时，中方可派员到蒙古国，对其上述体系或计划的实施情况进行实地核查评估。蒙方应提供必要的协助和便利条件。

## 第四条

蒙方确认：

（一）蒙古国境内无牛瘟、牛传染性胸膜肺炎，牛海绵状脑病、裂谷热、牛结节性疹、小反刍兽疫。

蒙古国对口蹄疫实施区域化管理，无疫区内过去 12 个月内无口蹄疫病例。

蒙古国按照世界动物卫生组织（OIE）的规定对牛海绵状脑病进行了监测和防控，监测结果表明蒙古国无牛海绵状脑病病例。

（二）蒙古国已建立有效的追溯体系，确保可以追溯到屠宰牛的出生和生长的地区（苏木）和动物群体。

（三）蒙古国已实施了饲料禁令禁止使用反刍动物源性成份（奶及奶制品、皮张制成的明胶和胶原、无蛋白和脂肪残留的磷酸二钙除外）饲喂反刍动物，并有有效的监督体系以保证该项禁令的实施。

（四）如蒙古国境内发生上述疾病、或其规定的口蹄疫无疫区内发生口蹄疫、或发生中蒙双方关注的与牛相关的其它恶性传染病时，或发生严重的食品污染事件时，蒙方应立即通知中方，提供详细报告并按国际惯例暂停对华出口，并召回可能受污染的产品。

如蒙古国境内发生除上述疫病以外的OIE规定的其它须通报动物疫病并严重影响到牛的健康，或发生食品安全污染事件时，蒙方也应立即通知中方，提供详细报告并按照国际惯例暂停受影响区域的肉类产品对华出口，并召回可能受污染的产品。

蒙方为恢复其产品的出口，应向中方提供关于疫情或污染状况、控制措施及疫情或污染得到良好控制等内容的详情报告，并根据国际惯例与中方协商恢复出口的条件。

**第五条**

用于生产向中国输出牛肉的牛须符合下列条件：

（一）出生并一直饲养于蒙古国口蹄疫非免疫无疫区，具有唯一身份标识，且标识具有可追溯性。

（二）来自符合下列条件的省份：

1.经中方正式确认、允许对中国出口牛肉的省份。

2.在过去 12 个月内，该省份没有从蒙古国的口蹄疫非免疫无疫区以外的地区引进过任何偶蹄类动物。

3.该省份被纳入了国家残留监控计划，根据计划结果证明，向中国出口的牛肉不含有害人体健康的药物、化学残留和其他有毒有害物质残留。

（三）来自符合下列条件的地区（苏木）：

1.在过去 6 个月内，该地区（苏木）未因动物疾病受到过检疫限制

或监测。

2.过去 6 个月内，该地区（苏木）没有发生水泡性口炎、蓝舌病、牛结核病、炭疽病、狂犬病、布氏杆菌病、伪狂犬病、Q 热、心水病和副结核病的临床病例。

（四）动物屠宰前至少在最后一个省份饲养了 60 天。动物屠宰前至少 14 天没有接种炭疽活疫苗。

（五）动物从未饲喂过反刍动物成份（奶及奶制品、皮张制成的明胶和胶原、无蛋白和脂肪残留的磷酸二钙除外）的饲料；从未使用过中蒙两国禁止使用的兽药和饲料添加剂。

（六）宰前宰后检验检疫过程中没有显示出任何炭疽、结核病和布氏杆菌病的临床症状或病理变化。如在宰前宰后检验检疫时发现上述疾病，来自同一批牛和同一养殖群体的牛肉不得向中国出口。

**第六条**

向中华人民共和国输出牛肉的生产企业（包括屠宰、加工和储存企业）应设在蒙方确认的口蹄疫非免疫无疫区、且中方确认允许对中国出口牛肉的省份内，符合中华人民共和国和蒙古国法律法规中有关兽医卫生和公共卫生的要求，由中国国家认证认可监督管理局根据中华人民共和国《进口食品境外生产企业注册管理规定》进行注册。未获得注册的肉类生产企业的产品不得向中国出口。

**第七条**

蒙古国官方兽医应行使下列职能：

（一）依照蒙古国和中国的有关法律法规对用于生产输华牛肉的牛

实施宰前宰后检验检疫。

（二）证明所有屠宰动物符合本议定书第四条和第五条的要求，动物是健康的，无动物传染病、寄生虫病的临床症状，胴体和脏器无病理变化。

（三）证明牛只屠宰后，胴体剔骨前在不低于2°C的环境下经过至少预冷和熟化24小时。经检测 ,胴体两侧背最长肌中部的pH 值小于5.9，且胴体上的主要淋巴、腺体组织已去除。

（四）证明肉类产品是在蒙古国官方主管机构的监督下以 HACCP 为基础的质量保证体系下生产的，未受到致病微生物污染，符合蒙古国及中国的法律法规规定。

（五）证明产品中兽药、农药、重金属及其他有毒有害物质的残留量不超过蒙古国和中国规定的最高残留限量，且不含有中国和蒙古国规定的禁用物质。

（六）证明产品是卫生、安全的，适合人类食用。

（七）一旦发现违反（一）至（六）所述，应立即通报中方，暂停相关企业的产品出口。蒙方将调查原因并采取相应整改措施，包括召回可能受污染的产品。

**第八条**

用于屠宰向中华人民共和国输出牛肉的牛，不得与不符合本议定书第四条和第五条规定的牛一起屠宰。向中国输出的牛肉不得与不符合本议定书第四条、第五条和第七条规定的牛肉一起加工。向中国输出的牛肉在加工和储存的各个阶段都应易于识别和追溯，保证只有符合本议定书要求的产品才能出口到中国。向中国输出的牛肉应单独存放在专门的区域。

## 第九条

向中华人民共和国输出的牛肉产品，内外包装必须使用符合国际卫生标准的无毒、无害的全新材料包装，完好无破损；内外包装上应当标明产地国、品名、生产企业注册号、生产批号；外包装上应当以中文标明规格、产地（具体到州/省/市）、目的地、生产日期、保质期、储存温度等内容，目的地应当标明为中华人民共和国，加施蒙古国官方检验检疫标识。

## 第十条

向中国输出的牛肉，从包装、存放到运输的全过程，均应符合卫生条件，防止受有毒有害物质的污染。运输过程中不得经过因发生疫病而受到限制或监测的地区。货物装入集装箱后，应在蒙古国官方兽医检察员的监督下加施铅封，铅封号须在卫生证书中注明。运输过程中不得拆开及更换包装。冷冻肉的中心温度不应高于-18℃。

## 第十一条

向中国输出的每一集装箱牛肉应随附至少一份蒙古国官方出具的正本卫生证书原件，证明该批产品符合蒙古国及中国兽医卫生和公共卫生法律法规及本议定书的有关规定。

卫生证书用中文、蒙文和英文写成，卫生证书的格式、内容须事先经双方确认认可。

蒙方在出具纸质证书的同时，还须及时将证书的电子信息在货物抵达前通过双方确定的方式发送给中方。

**第十二条**

必要时，中方将派出肉类检验检疫监管官员到蒙古国输出牛肉相关的地区（苏木）、肉类生产企业（包括屠宰、加工和储存企业）、实验室、出境口岸等配合蒙方对输华牛肉进行检验检疫。蒙方应提供必要的协助和便利条件。

**第十三条**

向中国输出的牛肉必须经中方指定的进口肉类指定口岸进口。如果中方发现输入的牛肉违反本议定书的有关规定，中方将立即通知蒙方，并根据中国有关法律法规要求，对产品作退回、销毁或其它处理。蒙方将和中方合作调查和解决问题，包括向中方通报已采取的补救措施如召回其它可能有问题的产品，防止此类事件再次发生。

**第十四条**

本议定书所称牛肉是指冷冻的带骨和剔骨牛肉，不包括头部和蹄部、脊髓、脊柱、背根神经节、内脏及其它副产品。

**第十五条**

本议定书经双方协商同意，可以修改。修改部分的生效日期由双方协商决定。

**第十六条**

中方或蒙方中的任一方可以通过提前六个月向另一方以书面通知的

方式终止本议定书。

**第十七条**

中方或蒙方中的任一方可以在任何时候通过官方渠道提出磋商的申请。磋商的时间与地点将由双方协商决定。

**第十八条**

本议定书自签字之日起生效。

本议定书用每份用蒙文、中文和英文写成，于2016年8月29日在乌兰巴托市签署。三种文本具有同等的法律效力。如存在异议，以英文为准。

**蒙古国**
**国家技术监督总局**
**代　表**

**中华人民共和国**
**国家质量监督检验检疫总**
**代　表**

## МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, ХОРИО ЦЭЭРИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР ХООРОНД БНХАУ-Д АДУУНЫ МАХ ЭКСПОРТЛОХТОЙ ХОЛБОГДСОН ХЯНАЛТ, ХОРИО ЦЭЭР, МАЛ ЭМНЭЛЭГ АРИУН ЦЭВРИЙН ШААРДЛАГЫН ТУХАЙ

## ПРОТОКОЛ

Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн яам /цаашид Монголын Тал гэх/, БНХАУ-ын Чанарын хяналт, шалгалт, хорио цээрийн ерөнхий газар /цаашид Хятадын Тал гэх/ Монгол улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-д адууны мах экспортлохтой холбогдсон хяналт, хорио цээр, мал эмнэлэг ариун цэврийн шаардлагын талаархи асуудлыг нөхөрсөгөөр хэлэлцэн дараах зүйлсийг тохиролцов. Үүнд:

### НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Монгол Улсын холбогдох байгууллага нь БНХАУ-д экспортлох адууны махны хорио цээр, хяналтыг хариуцаж мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ олгоно.

### ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Монголын Тал нь Хятадын Талд боловсруулах үйлдвэрүүд (нядлах, боловсруулах, хадгалах үйлдвэрүүд)-ийн зохицуулах хууль, заавар, журам, хяналт, хорио цээрийн нөхцөл, аргачлал, үйл явц болон адууны мах экспортлоход тавигдах стандартуудыг хүргүүлнэ. Мөн Монголын Тал нь Хятадын Талд албан ёсны хорио цээрийн тамга, мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээний эх хувь, албан ёсны малын эмч нарын гар бичмэл, түүнийг таних загвар, адууны махны үзлэгийн тамга, савлагааны шошгын загваруудыг хүргүүлнэ. Түүнчлэн Монголын Тал нь дээрх мэдээлэл өөрчлөгдсөн, дахин засварлах болсон тухай мэдээллийг 1 (нэг ) сарын өмнө Хятадын Талд мэдэгдэнэ.

Монголын Тал Хятадын Талд жил болгон жил бүрийн үлдэгдлийн хяналт, үнэлгээний хөтөлбөр ба түүний хорт болон аюултай химийн нэгдлүүдийн хяналтын хэрэгжилт, ялангуяа үлдэгдлийн хяналт үнэлгээний жил бүрийн тайлан, эмгэг төрүүлэгч микробуудын хяналтын хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаархи мэдээллийг хүргүүлнэ. Хятадын Талаас тавьсан хүсэлтийн дагуу Монголын Тал нь гурав, дөрөв дүгээр зүйлд заасан өвчнүүдийн урьдчилан сэргийлэх, хяналтын тогтолцооны талаарх мэдээлэл болон өвчний талаархи сэтгүүлийг хүргүүлж байна.

Хэрэв шаардлагатай гэж үзвэл эхний экспортын өмнө буюу дараагийн үйл ажиллагааны явцад Хятадын Тал Монголын Талд дэмжлэг үзүүлэхээр дээр дурьдсан хяналтын тогтолцоо болон үлдэгдэл, микробиологийн хяналтын хөтөлбөрүүд, тэдгээрийн хэрэгжилтийн байдалтай газар дээр нь танилцах зорилгоор экспертүүдээ илгээж болно.

## ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Монголын Тал нь Монгол Улсыг африкийн адууны тахал, цэвруут стоматит, адууны энцафаломиелит (өрнө, дорнын), вензсуэлийн адууны энцафаломиелит, оросын адууны энцафаломиелит, хулгана ... нийлүүлгийн өвчин, гүүний халдварт савны үрэвсэл, японы энцафаломиелит, су–ару (трипоносом), адууны халдварт ринопневмони, адууны вирусын артерит өвчнөөр тайван болон ям өвчнөөр сүүлийн 2 жил тайван байгаа тухайгаа албан ёсоор баталгаажуулна.

## ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Хятад улсад махыг нь экспортлох нядалгааны адуу дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Монголд төрж, бойжиж, нядлагдсан байх;

2. Сүүлийн 6 сар адууны халдварт цус багасах, адууны приплазмоз, боом өвчнөөс тайван аймаг, орон нутгаас бэлтгэгдсэн болохыг мэдэгдсэн байх;

3. Монгол Улсын мал, амьтны эрүүл мэндийн тухай журмын дагуу сүүлийн 6 сар өвчин гараагүй болон хорио цээр, хяналтын бүсэд хамрагдаагүй фермээс бэлтгэн нийлүүлэх ;

4. Олон улсын мал амьтны эрүүл мэндийн байгууллагын зааврын дагуу адууг нядлахаас 15-аас доошгүй хоногийн өмнө арьсны ямлуурын сорил ялангуяа энтрадерма-палпебрал сорил тавьж нядалгааны газар орохоос өмнө сөрөг дүн үзүүлсэн байх ;

5. Генийн инженерийн аргаар эсвэл генийн өөрчлөлтийн үр дүнд гарган авсан эх үүсвэрээр бэлтгэсэн тэжээлээр тэжээгдээгүй байх ;

6. Байгалийн эсвэл нийлэг гаралтай гормон, түүний бэлдмэл, бамбай булчирхайн бэлдмэл хэрэглээгүй байх;

7. Монголд хэрэгжүүлж буй хорт болон хөнөөлт бодисын үлдэгдлийн хяналт, үнэлгээ, ялангуяа эмгэг төрүүлэгч микробын хяналтын хөтөлбөрүүдэд хамрагдсан байх.

## ТАВДУГААР ЗҮЙЛ

БНХАУ-д адууны мах экспортлох, боловсруулах (нядлах, боловсруулах, хадгалах ) үйлдвэрүүд нь Монгол Улс, БНХАУ-ын мал эмнэлгийн ба нийгмийн эрүүл мэндийн шаардлага, хоёр улсын холбогдох хууль, журмуудад нийцсэн байна.

"БНХАУ руу бүтээгдэхүүнээ оруулах Гадаадын хүнсний үйлдвэрүүдийн бүртгэлийн байгууллагын журам"-ын дагуу БНХАУ-ын

Итгэмжлэл, баталгаажуулалтын газар (ИБГ)-т бүртгүүлсэн байна. Дээрх байгууллагад бүртгэгдээгүй үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг БНХАУ-д оруулахыг хориглох болно.

### ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

Монгол Улсын эрх бүхий малын эмч нар дор дурьдсан үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Нядлахын өмнөх болон нядалсны дараахь үеийн үзлэг, экспортлох адууны мах бэлтгэх адуунд хорио цээр тогтоох зэрэг арга хэмжээг Монгол Улс болон БНХАУ-ын холбогдох хууль, журмын дагуу хэрэгжүүлнэ.

2. Нядалгаанд орох адуу нь эрүүл, ямар нэгэн халдварт өвчний шинж тэмдэг болон шимэгч хорхой илрээгүй, гулууз мах, дотор эрхтэн, тунгалагийн зангилаанууд ямар нэгэн эмгэг, өөрчлөлтгүй болохыг албан ёсоор баталгаажуулна. Гулуузын гадарга гэмтээгүй байх ба тунгалагийн зангилаануудыг авсан байна.

3. Мал эм, химийн бодис, пестицид, хүнд металл болон бусад хортой, аюултай бодисын үлдэгдлийн хэмжээ Монгол Улс болон БНХАУ-д зөвшөөрөгдсөн дээд хэмжээнээс хэтрээгүй болохыг баталгаажуулна.

4. Бүтээгдэхүүн нь Монгол Улс болон БНХАУ-ын хууль, журмын дагуу ямар нэгэн эмгэг төрүүлэгчээр бохирдоогүй болохыг баталгаажуулна.

5. Бүтээгдэхүүн нь аюулгүй, эрүүл ахуйн шаардлага болон хүн амын хүнсний хэрэгцээнд нийцсэн байна.

6. Бүтээгдэхүүн нь нөжирсөн цус ба гадны биетээр бохирдоогүй, гаж үнэр, хүнсний нэмэлтгүй болохыг баталгаажуулна. Мөн бүтээгдэхүүн нь будагч бодис, ионжуулагч цацраг, хэт ягаан туяаны боловсруулалтанд ороогүй байна.

7. Өрөөл болон тал өрөөл гулуузыг үзлэгт орсныг баталгаажуулан тухайн үйлдвэрийн газрын бүртгэлийн дугаартай хяналтын тэмдгийг харагдахуйц байдлаар дарсан байх ба хэсэглэсэн болон жижиглэсэн төрлийн махны савлагаан дээр мал эмнэлгийн эрүүл мэндийн тамга дарсан байна. Баглаа, боодлыг задласны дараа дахин ашиглах боломжгүй аргаар хаягийг наасан байна.

8. Монголын Тал энэ зүйлийн 1 -ээс 7 дахь хэсэгт заасан шаардлага хангаагүй тохиолдол илэрснийг Хятадын талд даруй мэдэгдэх ба сэжиглэгдэж байгаа боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагааг зогсоож, нарийвчлан судалгаа хийж, бохирдсон бүтээгдэхүүнийг олж тогтоон, нөхцөл байдлыг залруулахын тулд шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлнэ.

### ДОЛДУГААР ЗҮЙЛ

БНХАУ-д адууны мах экспортлох үйлдвэрүүд нь гурав ба дөрөв дүгээр заалтын шаардлага хангаагүй адууг нядлах, махыг нь хэсэглэх боловсруулахыг хориглох бөгөөд гурав, дөрөв, тав дугаар зүйлийн шаардлага хангаагүй адууны махыг хамтад нь хадгалахыг хориглоно. Адууны махыг хадгалах хөргүүртэй агуулахад БНХАУ руу экспортлох гэж байгаа адууны махыг тусгайлан хурааж хадгална.

НАЙМДУГААР ЗҮЙЛ

БНХАУ руу экспортлох адууны махыг олон улсын эрүүл ахуйн стандартыг хангасан шинэ материалаар баглаж боосон байна. Тухайн бүтээгдэхүүний нэр, хэсэг, жин болон БНХАУ-ын Итгэмжлэл, баталгаажуулалтын газарт бүртгэлтэй үйлдвэрийн нэр, бүртгэлийн дугаар, хаяг, хадгалах нөхцөл, үйлдвэрлэсэн он сар өдөр, анхдагч /дотор талд/ болон хоёрдогч /гадна талд/ савлагааны шошго зэргийг хятад, англи хоёр хэлээр бичсэн байна. Хятадын талаас баталгаажуулсан хорио цээр, хяналтын тэмдгийг савлагааны гадна талд тэмдэглэсэн /дарсан/ байна.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

БНХАУ-д экспортлох адууны махны савлалт, хадгалалт, тээвэрлэлт нь мал эмнэлэг, ариун цэврийн шаардлага хангасан байх ба хортой болон аюултай бодисоор бохирдохоос сэргийлсэн байна. Тээвэрлэлтийн явцад бүтээгдэхүүний баглаа, боодол нь задрах болон солигдохоооргүй байна. Гулуузыг дотор эрхтнээс салгаж, угаасны дараа цельсийн 8 хэмд 24 цагийн турш зогсоож хадгална. Гулуузыг жижиглэх, хэсэглэх, шулах, савлах үйл ажиллагааг 4 хэмийн хүйтэнд гүйцэтгэсний дараа махыг цельсийн 4 хэмээс дээшгүй нөхцөлд хадгална. Хөлдөөсөн адууны махыг цельсийн хасах 18-аас дээшгүй хэмд хадгална.

АРАВДУГААР ЗҮЙЛ

БНХАУ-д экспортлох адууны махыг тээвэрлэх чингэлгээр зөвхөн энэхүү Протоколын шаардлагыг хангасан адууны махыг тээвэрлэх бөгөөд өөр төрлийн бүтээгдэхүүн тээвэрлэхийг хориглоно. Махыг ачсаны дараа чингэлгийг Монгол Улсын эрх бүхий малын эмчийн хяналтын дор битүүмжилнэ. Лацны дугаарыг мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээнд бичнэ. Тээвэрлэлтийн явцад чингэлэг нээгдэх боломжгүй ба сав баглаа боодол нь задарч өөрчлөгдөхөөргүй байна.

АРВАННЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

БНХАУ-д экспортлох адууны махны хэсэг тус бүрт мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээний эх хувийг дагалдуулна. Чингэлгээр тээвэрлэх үед чингэлэг бүрт мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээг дагалдуулах ба тухайн тээвэрлэлт нь энэхүү Протоколд тусгагдсанаар Монгол Улсын малын болон нийгмийн эрүүл мэндийн холбогдох хууль, журмыг мөрдөж байна гэдгийг баталгаажуулна. Түүнчлэн, илгээсэн ба хүлээн авсан газар, илгээгч болон хүлээн авагч байгууллагын нэр, хаяг, Итгэмжлэл,

баталгаажуулалтын газрын бүртгэлийн дугаар зэргийг мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээнд бичсэн байна.

Мал эмнэлгийн гэрчилгээг хятад, монгол /эсвэл англи/ хэлээр хэвлэсэн байна. Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, агуулгыг хоёр тал урьдчилан тохиролцоно.

АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Протоколын 3 дугаар зүйлд заасан болон Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ)-ын "шуурхай мэдээлэх" ангиллын өвчнүүд Монгол Улсад гарсан ба эдгээр өвчнөөр адууны мах нь халдварлагдсан байж болзошгүй тохиолдолд адууны махыг БНХАУ-д экспортлохыг даруй зогсоож, Хятадын Талд халдварт өвчний гаралт, түүнтэй тэмцэх, устгах арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлнэ.

Хэрэв энэхүү Протоколын 4 дүгээр зүйлд заасан болон ДМАЭМБ-ын "тогтмол мэдээлэх" ангиллын өвчнүүд гарсан ба адууны мах нь эдгээр өвчнөөр халдварлагдсан бүс нутгаас бэлтгэгдсэн байж болзошгүй тохиолдолд Монголын Тал Хятадын Талд эдгээр өвчний талаархи дэлгэрэнгүй мэдээллээр хангаж, тухайн бүс нутгаас адууны мах экспортлохыг зогсооно. Өвчний голомтыг устгасан эсвэл халдварлах аюул байхгүй болсон, дахин мах эскпорлохыг сэргээх тохиолдолд Монголын Тал Хятадын Талтай энэ талаар урьдчилан зөвшилцөнө.

АРВАНГУРАВДУГААР ЗҮЙЛ

Хятадын Тал энэхүү Протоколын шаардлага хангаагүй махыг экспортлосныг тогтоовол нэн даруй Монголын Талд мэдэгдэж, тухайн бүтээгдэхүүнийг буцаах, шалтгааныг тогтоох эсвэл устгах эсэхийг судална. Монголын Тал нь амархан гэмтэж болох аливаа бүтээгдэхүүнийг буцаах зэрэг аливаа асуудлыг илрүүлж шийдвэрлэх, яаралтай арга хэмжээг Хятадын Талд мэдэгдэх ба эдгээр асуудал дахин давтагдахгүй байхаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зэргээр Хятадын Талтай хамтран ажиллана.

АРВАНДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Энэхүү Протоколд заасан адууны мах гэдэгт дотор эрхтэн болон дайвар бүтээгдэхүүн /толгой, хөл, сүүл, зүрх, элэг, дэлүү, хэл, бөөр, ходоод, гэдэс, сав, давсаг гэх мэт/ ороогүй, хүнсний хэрэгцээний адууны ясгүй булчин мах хамаарна.

АРВАНТАВДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Протоколд хоёр тал харилцан зөвшилцөж, засвар оруулж болно.

## АРВАНЗУРГАДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Протокол нь гарын үсэг зурагдсан өдрөөс хүчин төгөлдөр болох бөгөөд 5 жилийн хугацаанд хүчинтэй байна. Хэрэв Талуудын аль нэг нь Протоколын нөхцлийг өөрчлөх эсвэл түүнийг хүчингүй болгох саналаа энэхүү Протоколын хугацаа дуусахаас 2 сарын өмнө бичгээр гаргаагүй бол хүчинтэй байх хугацаа нь дараагийн 5 жилийн турш аяндаа сунгагдаж байх болно.

Энэхүү Протоколыг Улаанбаатар хотноо 2005 оны 05 дугаар сарын 24-ний өдөр монгол, хятад, англи хэлээр үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

Хэрэв санал зөрвөл англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХОРИО ЦЭЭРИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН САЙД

.................................................... ....................................................

**ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХЭР, ХОНЬ, ЯМААНЫ МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ МОНГОЛ УЛС, БНХАУ-Д ЭКСПОРТОЛЖ, ИМПОРТЛОХ ҮЕИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ХОРИО ЦЭЭР, МАЛ ЭМНЭЛЭГ, АРИУН ЦЭВРИЙН НӨХЦЛИЙН ТУХАЙ**
**МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР, БНХАУ-ЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ХОРИО ЦЭЭРИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР ХООРОНДЫН ПРОТОКОЛ**

Монгол Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, БНХАУ-ын Чанарын хяналт, шалгалт, хорио цээрийн ерөнхий газар (цаашид "Талууд" гэх) хоорондын нөхөрсөг яриа, хэлэлцээний дүнд дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах, махан бүтээгдэхүүн (цаашид "боловсруулсан бүтээгдэхүүн" гэх) Монгол Улс, БНХАУ-д экспортолж, импортлохтой холбогдсон хяналт шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцлийн талаар дараах зүйлийг тохиролцов. Үүнд:

## Нэгдүгээр зүйл

Монгол Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон БНХАУ-ын Чанарын хяналт, шалгалт, хорио цээрийн ерөнхий газар нь энэхүү Протоколыг хэрэгжүүлэгч байгууллагууд байна.

Талууд нөгөө талдаа экспортод гаргах боловсруулсан бүтээгдэхүүний хорио цээр, хяналт шалтгалтыг хариуцаж, мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ олгоно.

## Хоёрдугаар зүйл

Үхэр, хонь, ямааны мах боловсруулах нядалгааны үйл ажиллагаатай холбогдолтой хууль, эрх зүйн баримт бичгүүд, боловсруулсан бүтээгдэхүүнийг экспортлохтой холбогдсон хяналт шалгалт, хорио цээрийг хийх арга, дэс дараалал болон стандарт, хорио цээрийн тамга дардас, мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээний загвар болон гарын үсэг зурж баталгаажуулах малын их эмчийн гарын үсгийн загвар, шалгалтын тэмдэглэгээ зэрэг баримт бичгүүдийг талууд харилцан бие биендээ хүргүүлнэ.

Энэхүү Протоколын 3 болон 4 дүгээр зүйлд заасан мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих тогтолцооны талаар Талууд харилцан мэдээлэх бөгөөд импортлогч сронд мал, амьтны халдварт өвчний талаарх мэдээллийг цаг тухайд нь өгч байна.

Талууд экспортолж буй боловсруулсан бүтээгдэхүүнтэй холбоотой малын эмийн үлдэгдэлд мониторинг, хяналт тавих төлөвлөгөө болон авч

хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх жилийн тайланг харилцан бие биедээ өгөх үүрэг хүлээнэ.

Дээр дурдсан зүйлд өөрчлөлт гарсан бол тухайн өөрчлөлт хүчинтэй болохоос нэг сарын өмнө нөгөө Талдаа мэдэгдэх ёстой.

Шаардлагатай үед Талууд шинжээчдээ тухайн газар оронд илгээж дээр дурдсан хяналтын тогтолцоо, удирдлага зохион байгуулалтын байдал, үүний дотор малын эмийн үлдэгдэлд мониторинг, хяналт тавих үндэсний түвшний төлөвлөгөө, малын халдварт өвчнийг хянах арга хэмжээ зэрэгтэй танилцаж болно.

## Гуравдугаар зүйл

Экспортлогч тал өөр өөрийн нутаг дэвсгэрт үхрийн тархи сархиатах өвчин, хонь, ямааны скрепи өвчингүй гэдгийг албан ёсоор баталгаажуулна.

## Дөрөвдүгээр зүйл

Экспортлогч талаас импортлогч талд нийлүүлэх боловсруулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх зорилгоор нядлах үхэр болон .хонь, ямааны хувьд дараахь шаардлага тавигдана. Үүнд:

а/ Экспортлогч улсад төллөн тэжээгдсэн байх;

б/ Сүүлийн 24 сарын дотор шүлхий, бог малын мялзан, үхрийн цээж болон тунгалагийн зангилаа, арьсны өвчин гараагүй фермээс гаралтай байх;

в/ Сүүлийн 12 сарын дотор боом, бруцеллез, Аускийн өвчин, сүрьеэ, галзуу, мелиоидоз болон параво вирусын өвчин гараагүй фермээс гаралтай байх;

г/ Сүүлийн 12 сарын дотор экспортлогч орны ариун цэврийн дүрэм журмын дагуу зарлагдсан үхэр, хонь, ямааны өвчин гарснаас болж хязгаарлагдсан эсхүл хяналтад орсон фермээс гаралгүй байх;

д/ Экспортлогч орон нь импортлогч оронд гаргах зориулалтаар нядлах үхэр, хонь, ямаа нь мал амьтны эд эс орсон тэжээлээр тэжээгдээгүйг нотолно.

## Тавдугаар зүйл

Экспортлогч орны боловсруулах түүхий эд болох үхэр, хонь, ямааны мах, махан бүтээгдэхүүн нь импортлогч оронд бүртгэгдсэн мал нядлах, боловсруулах аж ахуйн нэгжээс ирсэн байх ёстой. Экспортлох боловсруулсан бүтээгдэхүүнийг боловсруулах аж ахуйн нэгж нь өөрийн орны болон

импортлогч орны холбогдох мал эмнэлэг, ариун цэврийн хууль тогтоомж, дүрэм журмын шаардлагыг хангасан байх бөгөөд импортлогч орон өөрийн орны журмын дагуу экспортлогч орны холбогдох аж ахуйн нэгжийг бүртгэх ажлыг хийнэ. Бүртгэгдээгүй аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүнийг импортлогч оронд экспортлохгүй.

## Зургаадугаар зүйл

Хоёр талын албан ёсны малын эмч дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

а/ Монгол Улс болон БНХАУ-ын холбогдох хууль тогтоомж, журмын дагуу боловсруулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд хэрэглэх үхэр болон хонь, ямаанд нядлахын өмнө болон нядалсны дараах мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн хяналт шалгалтыг хийх;

б/ Нядалгаанд орж буй бүх үхэр, хонь, ямаа нь эрүүл бөгөөд ямар нэгэн мал, амьтны халдварт, паразит өвчний шинж тэмдэг байхгүй, гулууз мах болон эд эрхтэнд өвчний улмаас ямар нэгэн өөрчлөлт гараагүй болохыг батлах;

в/ Мах нь гормоны эмчилгээ хийлгээгүй малаас гаралтай байх ёстой бөгөөд малын эм бэлдмэлийг хэрэглэхдээ түүний хэрэглээг зогсоох хугацаа нь зохих хууль тогтоомж, дүрэм журамд чанд нийцсэн гэдгийг батлах;

г/ Түүхий эд болох үхэр болон хонь, ямааны мах нь импортлогч улсаас зөвшөөрөгдсөн нядлах, боловсруулах аж ахуйн нэгжээс ирсэн, нядлах, боловсруулах явц нь тавигдсан шаардлагын дагуу албан ёсны хяналтын дор хийгдсэн болохыг баталгаажуулах;

д/ Экспортын боловсруулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх явцад ашигласан нэмэлт материал нь Хятад ,Монгол Улсын тавигдах шаардлагад нийцсэн болохыг батлах;

е/ Экспортод гаргах боловсруулсан бүтээгдэхүүний түүхий эд, нэмэлт материал болон эцсийн бүтээгдэхүүн дэх малын эм, пестицид, хүнд метал, хүнсний нэмэлт, бусад хор, хөнөөлтэй бодисын үлдэгдлийн хэмжээ нь Хятад, Монгол Улсын тогтоосон дээд хязгаараас илүү гараагүйг батлах;

ё/ Бүтээгдэхүүн нь өвчин үүсгэгч бичил биетээр бохирлогдоогүй бөгөөд Хятад, Монгол Улсын хууль дүрмийн шаардлагыг биелүүлсэн болохыг батлах;

ж/ Холбогдох бүтээгдэхүүн нь цэвэр, аюулгүй, хүн хэрэглэхэд тохиромжтой болохыг батлах.

## Долоодугаар зүйл

Импортлогч оронд бүртгүүлсэн мал нядлах, боловсруулах аж ахуйн нэгж нь тухайн оронд экспортлох үхэр, хонь, ямааг нядлах, мах үйлдвэрлэхдээ энэхүү Протоколын 3 болон 4 дүгээр зүйлд заасан нөхцөлд нийцэхгүй үхэр, хонь, ямаатай цуг нядалж, боловсруулалт хийж болохгүй. Экспортлох боловсруулсан бүтээгдэхүүнийг энэхүү Протоколын 5 болон 6 дугаар зүйлд заасан нөхцөлд нийцэхгүй үхэр, хонь, ямааны махтай цуг боловсруулж болохгүй. Боловсруулсан бүтээгдэхүүнийг хөргөхдөө бусад түүхий эд, бүтээгдэхүүнээс тусад нь хөргөнө.

## Наймдугаар зүйл

Экспортлох боловсруулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч аж ахуйн нэгж нь дараахь шаардлагыг хангана. Үүнд:

а/ Усанд буцалгах, жигнэх болон тосонд шарахдаа үхрийн мах болон түүний гаралтай бүтээгдэхүүний төв хэсгийн дулааныг $80^{o}C$ болон түүнээс дээш температурт хүргэж 5 минут болон түүнээс дээш хугацаанд байлгана. Эсхүл бусад ямар ч арга хэрэглэсэн үхрийн мах болон түүний гаралтай бүтээгдэхүүний төв хэсгийн дулааныг $70^{o}C$ болон түүнээс дээш температурт хүргэж 30 минут байлгана.

б/ Усанд буцалгах, жигнэх болон тосонд шарахдаа хонь, ямааны мах болон тэргээрийн гаралтай бүтээгдэхүүний төв хэсгийн дулааныг $70^{o}C$ болон түүнээс дээш температурт хүргэж 5 минут болон түүнээс дээш хугацаанд байлгана. Эсхүл бусад ямар ч арга хэрэглэсэн хонь, ямааны мах болон тэргээрийн гаралтай бүтээгдэхүүний төв хэсгийн дулааныг $65^{o}C$ болон түүнээс дээш температурт хүргэж 30 минут байлгана.

в/ Үйлдвэрлэгч аж ахуйн нэгж тусгай хүн томилж бүтээгдэхүүнийг халаасны дараа төв хэсгийн дулааныг хэмжиж, махыг зүсч мэдрэхүйн шинжилгээ хийж, үйлдвэрлэх явцын дунд тэмдэглэл хийн, эцсийн бүтээгдэхүүний микроорганизмын үзүүлэлтийг шалгаж, шаардлагатай үед уургийг денатурат болгох туршилтыг хийж бүтээгдэхүүн бүрэн боловсорсон эсэхийг баталгаажуулна.

## Есдүгээр зүйл

Импортлогч орон руу гаргах боловсруулсан бүтээгдэхүүнийг олон улсын ариун цэврийн стандартыг хангасан шинэ материалаар боож баглана. Гадна баглаан дээр монгол, хятад, англи хэлээр стандарт, үйлдвэрлэсэн газар, очих газар, бүтээгдэхүүний нэр, жин, үйлдвэрлэгчийн нэр, бүртгэлийн дугаар, үйлдвэрлэлийн цувааны дугаар, хадгалах нөхцөл, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа, хоёр талаас тэмдэглэсний дагуу хяналт шалгалт, хорио цээрийн нөхцлийг хангасан тэмдэглэгээг заасан байна. Дотор баглаан

дээр үйлдвэрлэгч орны нэр, бүтээгдэхүүний нэр, аж ахуйн нэгжийн бүртгэлийн дугаар, үйлдвэрлэлийн цувааны дугаарыг заасан байна. Дотор, гадна баглаан дээр мөн зөвхөн импортлогч оронд борлуулахыг заасан тэмдэглэгээг заавал хийнэ (тухайлбал, "зөвхөн Хятадын эх газарт борлуулна", "зөвхөн Монгол Улсад борлуулна" гэх мэт).

## Аравдугаар зүйл

Импортлогч оронд гаргах боловсруулсан бүтээгдэхүүн нь баглах, хадгалах, тээвэрлэх бүхий л явцад мал эмнэлэг, ариун цэврийн нөхцлийг хангасан байх бөгөөд хортой, аюултай бодисоор бохирдохоос сэргийлнэ. Баглаа боодол, хадгалалт, тээвэрлэлт нь бүтээгдэхүүний чанар, ариун цэврийг хангасан зохистой температур, нөхцөлд хийгдэнэ.

Барааг контейнерт ачсаны дараа экспортлогч орны албан ёсны малын их эмчийн хяналтын дор лацдаж, лацны дугаарыг барааны гэрчилгээнд заасан байна. Тээвэрлэлтийн явцад лацыг онгойлгож, баглааг солихгүй.

## Арван нэгдүгээр зүйл

Экспортлох боловсруулсан бүтээгдэхүүний багц бүрт ариун цэврийн гэрчилгээний эх хувийг дагалдуулах бөгөөд тухайн гэрчилгээ экспортлогч орны мал эмнэлэг, ариун цэврийн холбогдох хууль тогтоомж болон энэхүү Протоколын холбогдох заалтуудад нийцсэн болохыг батална. Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээг монгол, хятад, англи хэлээр бичсэн байх ёстой бөгөөд гэрчилгээний загвар, агуулгыг урьдчилан хоёр тал тохиролцоно.

## Арван хоёрдугаар зүйл

Экспортлогч оронд энэхүү Протоколын 3 дугаар зүйлд заасан халдварт өвчин эсхүл томоохон хэмжээний бохирдол гармагц импортлогч оронд даруй мэдэгдэж, халдварт өвчин болон бохирдлын талаарх мэдээллийг илгээхийн зэрэгцээ экспортоо даруй зогсооно. Халдварт өвчнийг бүрмөсөн устгах эсхүл томоохон хэмжээний бохирдол дуусгавар болсны дараа хэрэв экспортыг сэргээх бол урьдчилан хоёр талын зөвшөөрлийг авах хэрэгтэй.

## Арван гуравдугаар зүйл

Импортлогч орон холбогдох хууль тогтоомжийн дагуу төлөөлөгч илгээж экспортлогч орны бүртгэлтэй нядлах, боловсруулах үйлдвэр болон дулааны аргаар боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд тогтмол, тогтмол бус шалгалт хийж, сайжруулах шаардлагатай боловсруулах үйлдвэрт тогтоосон хугацаанд сайжруулалт хийх эсхүл экспортыг зогсоох зэрэг засч сайжруулах саналыг өгнө. Экспортлогч орны хэрэгжүүлэгч байгууллага нь хяналт тавьж сайжруулах арга хэмжээ авч импортлогч орны хэрэгжүүлэгч байгууллагад хэрэгжилтийн байдлын талаар мэдээлнэ.

## Арван дөрөвдүгээр зүйл

Энэхүү Протоколд боловсруулсан бүтээгдэхүүн гэж үхэр хонь ямааны ясгүй шууд хэрэглэх гол түүхий махыг хэлэх бөгөөд тэдгээр нь хоёр талаас зөвшөөрөгдсөн аргаар боловсруулагдсан байна. Үүнд цус, толгой, сүүл, шийр,туурай, дотор эрхтэн орохгүй.

## Арван тавдугаар зүйл

Талууд хэлэлцэн тохиролцож энэхүү Протоколд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Энэхүү Протоколыг 2011 оны 10 дугаар сарын 27-ний өдөр Далянь хотноо монгол, хятад, англи хэлээр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй. Протоколыг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

| | |
|---|---|
| МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ: | БНХАУ-ЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, ХОРИО ЦЭЭРИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ: |

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

# Чанаж боловсруулсан мах. Техникийн ерөнхий шаардлага

**MNS 6790 : 2019**

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
БОЛОВСРУУЛАГЧИД
ОЛГОСОН ХУВЬ

Албан хэвлэл

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР ХОТ

2019 он

СТАНДАРТЧИЛАЛ ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
СТАНДАРТЫН БОЛОВСРУУЛАГЧИД ОЛГОСОН ХУВЬ

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**Ангилалтын код: 67.120.10**

| | |
|---|---|
| **Чанаж боловсруулсан мах. Техникийн ерөнхий шаардлага** | **MNS 6790 : 2019** |
| **Boiled meat. General technical requirements** | |

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн С/63 дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандартыг 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөсэхлэн мөрдөнө.

## 1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь малын махыг экспортын зориулалтаар чанаж боловсруулсан мах үйлдвэрлэх, шалгаж хүлээн авах, савлах, шошголох, хадгалах, тээвэрлэх, хяналт тавихад хамаарна.

## 2 Норматив эшлэл

Уг стандартад олон улсын болон дараах үндэсний стандартуудаас эш татаж хэрэглэсэн бөгөөд хэрэв эдгээр стандартад өөрчлөлт орвол хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг баримтлана. Үүнд:

*MNS CAC RCP 58:2013, Махны эрүүл ахуйн дадлын дүрэм;*
*MNS 2551:89, Мах, махан бүтээгдэхүүнийг шалгаж хүлээн авах ба сорьц авах, мэдрэхүйн эрхтнээр үнэлгээ өгөх журам;*
*MNS 6308:2012, Хүнсний бүтээгдэхүүн дэх бичил биетний аюулгүй байдал болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ;*
*MNS CAC MRL 2:2009, Хүнсний бүтээгдэхүүн дэх малын эмийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ;*
*MNS 4504:2008, Хүнсний бүтээгдэхүүн дэх хүнд металын үлдэгдлийн зөвшөөрөгдөх хэмжээ;*
*MNS 5868:2008, Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ;*
*MNS CAC 193:2007, Хүнсний бүтээгдэхүүн дэх хорт болон бохирдуулагч бодисын ерөнхий стандарт;*
*MNS 6648:2016, Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын шошгололтод тавих шаардлага.*

## 3 Нэр томьёо, тодорхойлолт

**3.1**
**чанаж боловсруулсан мах**
яснаас нь салгаж ангилан, амтлагч нэмэлгүй чанасан мах

Тайлбар: Үхрийн махны гүний температурыг 80 $^0$C, хонь, ямааны махны гүний температурыг 70 $^0$C хүрсэн мөчөөс эхлэн тухайн температурт 5 минутаас дээш хугацаанд байлгаж барина.

## 4 Техникийн шаардлага

**4.1** Чанаж боловсруулсан махыг “MNS CAC RCP 58:2013, Махны эрүүл ахуйн дадлын дүрэм” стандартын шаардлага хангасан үйлдвэрт зохих журмын дагуу баталгаажуулсан жор, технологийн зааврын дагуу үйлдвэрлэнэ.
**4.2** Чанаж боловсруулах мах нь үхэр, ямаа, хонины I ба II зэргийн шинэ, сэврээсэн, хөргөсөн мах болон нэг удаа гэсгээсэн мах байх ба дараах стандартын шаардлагыг хангасан байна. Үүнд:

*MNS 4496:97 Хүнсний бүтээгдэхүүн хар тугалгын агуулгыг тодорхойлох атом шингээлтийн спектрометрийн арга;*
*MNS 4499:97, Хүнсний бүтээгдэхүүнд кадьмийн агуулгыг тодорхойлох атом шингээлтийн спектрометрийн арга.*
*MNS 4516:97, Хүнсний бүтээгдэхүүнд цагаан тугалгын агуулгыг тодорхойлох атом шингээлтийн спектрометрийн арга*
*MNS 4833:99 Хүнсний бүтээгдэхүүнд хлорорганик пестицид тодорхойлох нимгэн үет хроматографийн арга;*
*MNS 4832:99 Хүнсний бүтээгдэхүүнд фосфор органик пестицид тодорхойлох нимгэн үет хроматографийн арга;*
*MNS 5076:2013, Малын гаралтай хүнсний (мах, сүү) бүтээгдэхүүнд цацраг идэвхит элементийг тодорхойлох. Гамма спектрометрийн арга.*

## 6 Савлалт, хаяглалт

**6.1** Бэлэн бүтээгдэхүүнийг импортлогч талын захиалсан сав баглаа боодол болон "MNS 5547:2005, Хүнсний бүтээгдэхүүний нийлэг сав баглаа боодол". Техникийн ерөнхий шаардлага" стандартын шаардлага хангасан хүнсний зориулалтын нийлэг хальсан уутанд савлана.

**6.2** Савласан бүтээгдэхүүний жингийн хэлбэлзэл ± 1,5 %-аас ихгүй байна.

**6.3** Савласан бүтээгдэхүүнийг эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан хайрцаг, саванд савлана.

**6.4** Савласан бүтээгдэхүүний сав баглаа боодол нь импортлогч орны шаардлагад нийцсэн мэдээлэл бүхий шошготой байна.

## 7 Хадгалалт, тээвэрлэлт

**7.1** Бүтээгдэхүүнийг 60 %-аас ихгүй агаарын харьцангуй чийглэгтэй, -18 $^{0}$C-ээс ихгүй температуртай, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд хөлдүү байдлаар нь 6 сар хүртэл хугацаагаар хадгалж болно.

**7.2** Бүтээгдэхүүнийг "MNS CAC RCP 1:2003, "Хүнсний эрүүл ахуйн дадлын зөвлөмж" стандартын шаардлага хангасан, зориулалтын хөргүүр бүхий тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

**ТӨГСӨВ.**

**Өмнөх үг**

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллагын (ОУСБ) гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үндэсний стандартчиллын бодлогыг хэрэгжүүлэх ажил эрхэлдэг.

Стандартын төсөл боловсруулах ажлыг салбарын стандартчиллын техникийн хороо (ТХ), дэд хороо (ДХ) эрхлэн гүйцэтгэдэг бөгөөд техникийн хорооны хурлаар хэлэлцэж, 75%-иас доошгүй хувийн саналаар дэмжиж, зөвшилцсөн төслийг Стандарт, хэмжил зүйн газрын даргын тушаалаар батлаcнаар хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг  Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Т.Гантогтох, мэргэжилтэн Ц.Гэрэлмаа, Монголын махны холбооны гүйцэтгэх захирал Б.Очирбат, ажилтан И.Баттогтох, Мах маркет ХК-ийн ерөнхий технологич Л.Энхтуяа, "Преком" ХХК-ийн захирал Б.Мөнхзаяа нар боловсруулж, СХЗГ-ын ахлах мэргэжилтэн Д.Даваасүрэн "MNS 1-2:2006, Монгол улсын стандартчиллын тогтолцоо. 2-р хэсэг: Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм" стандартад нийцүүлсэн.

Мах, шувуу, загас, өндөг, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний стандартчиллын дэд хороогоор хэлэлцэн, зөвшилцсөн болно.

**Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)**
Энхтайваны өргөн чөлөө 46А
Улаанбаатар Ш/Х – 48
Утас 266754, 263860 Факс (976-11) 458032
web: www.masm.gov.mn, www. estandard.gov.mn,
E-mail: standardinform@masm.gov.mn
**© СХЗГ, 2019**

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

*MNS 1111:2007, Үхэр, өсвөр үхэр, адууны өрөөл, тал өрөөл, хонь, хурга, ямааны гулууз мах. Техникийн ерөнхий шаардлага;*
*MNS 2456:2009, Мах, махан бүтээгдэхүүн. Үхрийн хэсэглэж ангилсан мах. Ерөнхий шаардлага;*
*MNS 2457:2009, Мах, махан бүтээгдэхүүн. Хонь, ямааны хэсэглэж ангилсан мах. Ерөнхий шаардлага.*

**4.3** Махны гарал үүсэл нь мал эмнэлгийн гэрчилгээ, технологийн горимын хяналт, цахим системээр баталгаажсан байна.

**4.4** Чанаж боловсруулсан махны чанар нь мэдрэхүйн эрхтний үнэлгээгээр 1, эрүүл ахуй, аюулгүй байдлын үзүүлэлтээр 2-р хүснэгтэд заасан шаардлагыг тус тус хангасан байна.

1 дүгээр хүснэгт- Чанаж боловсруулсан махны мэдрэхүйн үнэлгээ

| Д/д | Үзүүлэлт | Шинж чанар |
|---|---|---|
| 1 | Биет байдал | Хатаж харлаагүй, жигд өнгөтэй, хуйхгүй, гадны бохирдолгүй, |
| 2 | Өнгө | Гадаргуу нь жигд бор шаргал, өнгөтэй, өөх нь цагаанаас цайвар шаргал өнгөтэй |
| 3 | Үнэр | Чанасан махны өвөрмөц үнэртэй, гадны үнэргүй |
| 4 | Зүсэлтэнд | Зүсээд гэсгээж шахаж үзэхэд шүүс нь улаан бус гүйцэт болцтой, жигд бор шаргал өнгөтэй. |

2 дугаар хүснэгт- Чанасан махны эрүүл ахуй, аюулгүй байдлын үзүүлэлт

| Д/д | Үзүүлэлт | Зөвшөөрөх хэмжээ |
|---|---|---|
| 1 | Бичил биетний эрүүл зүйн болон аюулгүй байдлын үзүүлэлт | MNS 6308 :2012 стандартын шаардлагад нийцсэн байна. |
| 2 | Эм, биобэлдмэлийн үлдэгдэл, мг/кг | MNS CAC MRL 2:2017 стандартын шаардлагад нийцсэн байна. |
| 3 | Хүнд металлын үлдэгдэл, мг/кг | MNS 4504:2008 стандартын шаардлагад нийцсэн байна. |
| 4 | Пестицидийн үлдэгдэл, мг/кг | MNS 5868:2008 стандартын шаардлагад нийцсэн байна. |
| 5 | Цацраг идэвхт бодисын үлдэгдэл, Бк/кг | MNS CAC 193:2007 стандартын шаардлагад нийцсэн байна. |

## 5 Шалгаж, хүлээн авах

Чанаж боловсруулсан махны чанар, аюулгүй байдлыг тодорхойлоход дараах стандартыг ашиглана. Үүнд:
*MNS 2551:89, Мах, махан бүтээгдэхүүнийг шалгаж хүлээн авах ба сорьц авах, мэдрэхүйн эрхтнээр үнэлгээ өгөх журам;*
*MNS ISO 3100-1:2000, Микробиологи. Мах, махан бүтээгдахүүн. Дээж авах ба шинжилгээний сорьц бэлтгэх;*
*MNS 1161:2002, Мах, махан бүтээгдэхүүн. Махны шинэлэг байдлыг тодорхойлох шинжилгээний арга;*
*MNS 4080:88, Мах махан бүтээгдэхүүн. Маханд хийх шинжилгээний арга ба мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээний зарчим;*
*MNS ISO 6579:99, Микробиологи. Салмонелл илрүүлэх ерөнхий заавар*
*MNS 6569:2016, Хүнсний бүтээгдэхүүн дэх малын эм, бэлдмэлийн үлдэглийн агууламжийг тодорхойлох өрсөлдөөнт иммуноферментийн арга;*